

НАЦАГДОРЖ, ЗОХИОЛУУДДАА ГАДААД ҮГИЙГ ХЭРЭГЛЭСЭН ТУРШЛАГА

Б.Пүрэв-Очир*

Мой верный друг,
мой друг коварный,
мой царь,
мой раб -
родной язык! (В.Брюсов)

Хүн судлаачид, хэлшинжээчид, сэтгэл судлаачид, гүн ухаантнууд, физикчдээс өгсүүлээд, уран илтгэгчид, эзотерикч нар, яруу найрагчид, зохиолч-нийтлэлч нар хүртэл дэлхийн олон хэлний авианы нийлэмж, зохицол, үг өгүүлбэр хорших ёс, үг хэллэг, метафор загварчлал, эдгээрийн хэрэглээ, соёл, эрчим энергийг судалж төнхөөд, хүмүүний хэлний үг хэллэг, өгүүлбэрийг ид шидтэй, ухааны болон сэтгэхүйн хүчирхэг зэвсэг, багаж гэж үзсээр иржээ.

Бас ойрын ба холын төрөл садан-дэлхийн олон хэл нь бие биед өглөгийн гараа сунгаж, хүн-нийгэм хийгээд соёл хоорондын харилцааны явцад олон мянган үг, утгыг бие биедээ өгч, авсаар ирж. Тэр нь соёлын харилцаа, ярианы болон бичиг зохиолын хэлээр дамжин хэрэгждэг жам ёстой аж. Эндээс үүдэж, алив хэлний үг-утгын сан хөмрөгт “харь үг”, “гадаад үг”, “зээлбэр үг”, “ормол үг”, “олон улс дундын үг” г.м. ухагдахуун, ойлголт, нэртөмьёо гарч, нэг хэл, нэг соёлын хам хүрээнээс хальж, олон хэл, олон соёлын харилцаа, бие биед нэвчих ёс, хэм хэмжээг илэрхийлж ирж.

Хүмүүний харилцахуйн багаж зэвсэг-үг хэлийг ярианы, сонин нийтлэлийн, албан хэргийн, эрдэм шинжилгээний, **уранзохиолын** г.м. найруулгын үндсэн төрлүүдэд хэрэглэх, гадаад үг, нэртөмьёо, олон улс дундын үгийг орчуулан буулгаж хэрэглэх, эс орчуулан хэрэглэх г.м. асуудал бол цаг цагийн уран зохиол, утга соёл, найруулгад бас л хуультай, хязгаартай байдаг.

Урансайхны найруулгад л гэхэд 20-30-аад оныхон дотроос харь үг-гадаад үг хэллэгийг өөрийн зохиол бүтээлд оновчтой, онцлогтой, гайхалтай баялаг сайхан хэрэглэсэн зохиолч бол бараг гагц Дашдоржийн Нацагдорж гэж хэлэх үндэстэй байна.

Нацагдорж бол алс газар аа сураар одож, эрдэм боловсролын сувд таныг шүүрдэж ирсэн, шинэ цагийн сайн боловсрол гэгээрэлтэй сэхээтний нэгэн байсан. Ялангуяа цаг үеийнхэн дотроо гадаад хэлний мэдлэг боловсрол сайтай, олон хэлний зах зухтай, зарим хэлийг нь тун чамбай сайн эзэмшсэн, бусад хэлийг шимтэн сонирхдог хүн байв.

Нацагдоржийн амьдрал, уран бүтээлийг ултай сайн судалсан эрдэмтэн С.Лочингийн тэмдэглэснээр: “Их зохиолч Нацагдорж нэгэн анкетдаа: “-Бусад хэл хэр мэдэх?” гэсэн асуултад: орос, герман, бас нэгтгээд, орос, герман, англи мэднэ гэж хариулсан бий. Бас нэг өөр газар орос, герман хэл мэднэ, англи, хятад хэл төсөөлнө гэж ч бий. Нацагдорж, Монголын хуучны бичигтэй хүний ёсоор дорно дахины хэд хэдэн хэл мэддэг байсан тухай дуртхал бий. Энэ бүхэн бол Нацагдорж олон хэл мэддэг хүн байсан, **орчуулах** түвшинд байсан гэдэг нь баримтаар бүрэн батлагдаж байгаа юм.” (М.З.Э.”Нацагдоржийн уламжлал, утга зохиолын өнөөгийн

*Монгол Улсын Боловсролын Их Сургууль

зангилаа асуудлаад”, Уб., 1990) гэсэн байна.

Тэрээр, К.Марксын “Капитал” зохиолын нэгдүгээр ботийн “Товар ба мөнгө” хэмээх тэргүүн ангиас; Шинжлэх ухааны хүрээлэнгийн захиалгаар Г.Е.Гржимайлогийн “Монголын түүхээс; Марко Пологийн жуулчлалын “Их хааны ордонд” гэсэн бичгээс; Оросын дипломатич Кростовецийн “Чингис хаанаас Зөвлөлт Бүгд Найрамдах улс хүртэл” номын зарим бүлгээс орчуулж байсан тухай мэдээ баримтыг судлаач нар тэмдэглэжээ. Бас тэрээр Оросын их найрагч А.С.Пушкиний “Анчар” (1828) (орч.1936), “Пробуждение” (1816) (орч.1936), “Земля и море” (1821) (орч.1936), “Узник” (1822) (орч.1936), “Ворон летит к ворону” (1828) (орч.1936) гэх зэрэг алдарт шүлэг болон Английн зохиолч Эдгар Аллан По-гийн “Алтан цох” зэрэг зохиолыг орчуулсан. Бас Д.Нацагдорж, “Герман-Монгол толь бичиг” зохиож байж. (Хэл зохиолын хүрээлэн, гар бичмэл, 546 хуудас бүхий.) Энэ бүхэн нь их зохиолч орос, герман хэлний сайн боловсролтой, орчуулах эрдмийн авьяас билэгтэй, гадаад хэл, түүх, соёлын боловсролдоо ихэд анхаардаг хүн байсныг илтгэдэг. Тиймээс ч их Нацагдорж өөрийн анхны зохиолуудаас эхлээд л “Хэлхээ үгүй сувд”-ыг хүртэлх зохиолдоо олон улсын дундын үг, гадаад үг хэллэгийг тун оновчтой, өвөрмөц хэрэглэсэн туршлага байна.

Д.Нацагдоржийн “Берлин явсан замын тэмдэглэл” (1927) бол баримтат-урансайхны зохиол. Энд өдий төдий газар ус, хот суурин, унаа хөсгийн нэрийг, заримы нь монгол үгийн авианы дуудлагад яльгүй нийцүүлэн **бэрвааз** (перевоз), **Торойцарь** (Тройцкосавск), Оросын **паар** (уурын) тэрэг, **Улаан яарсаг** хот (Красно-Ярск), **Об** (Обь) мөрөн, **Омсог** (Омск) хэмээх хот, **Баятка** (Вятка) хот, **Гасби** (Каспи)-ийн далай, **канал** (суваг), **Их Нева Штениний их банхув** (буудал) г.м.-ээр хэрэглэсэн нь сонин, өвөрмөц туршлага болсон билээ.

Их Нацагдорж, хэд хэдэн зохиолынхоо нэр-сэдвийг гадаад үгээр нэрлэсэн нь сонин байдаг. Үүнд:

- “...Пионер багачуудын дуу” (1925),
- “Пионер” лагерь дээр (1930),
- “МЮД” (1930),
- “Магнит” (1930),
- “Шансонет” (Завхай дуун) (1931),
- “Феодалын янаглал” (1931),
- “Октябрь” (1932),
- “Гуанзны хүүхэн” (1934),
- “Эрүүл пионер” (1935),
- “Нянгийн яриан” (1935),
- “Майн нэгнийг хөрөнгөтний газар үзжээ” (1928),
- “Амазонка” (1931) г.м. Үүний:

• “Пионер”¹- гэдэг үг нь франц гаралтай (pionnier) гэсэн үг бөгөөд “анхдагч эхлүүлэгч, залгамжлагч” гэсэн утгатай аж. Тиймээс ч Нацагдорж гуай “Залгамжлагчийг залгамжлагч” гэж бас монголоор давхар нэрлэсэн буй.

• “МЮД”, зарим түүвэр, судалгааны зүйлд “МИЮД” гэсэн буй. Энэ нь “Международный Юношеский День” гэдгийг товчилсон үг (Олон улсын залуучуудын өдөр) болно.

- “Магнит”, “соронзон” гэсэн утгаар хэрэглэсэн буй.
- “Лагерь” –герман хэлний үг. Lager, хүрээ, тал гэсэн утгатай аж.
- “Шансонет”, chansonnette гэсэн герман үг бөгөөд “Пикник” буюу хөдөө хээрийн зоогийн газар дуулдаг алиа наргиа (завхай) дууг хэлдэг аж.

• “Феодал”, “feodalis” гэдэг латин гаралтай үг, газрын эзэн, хамжлагат ноён гэжээ.

1. Эдгээр үгсийн тайлбар ба товч утга зэргийг д-р.Н.Балжиннямын «Монгол хэлний гадаад үгийн толь» (монгол-орос-англи) Уб., 2008 номд дулдуйдав.

- **“Гуанз”**, хятад хэлний “guan zi” буюу хоолны газар гэсэн үг.
- **“Нян”**, Төвд гаралтай “gnyan” гэсэн үг бөгөөд утгы нь анх төрмөл бичил махбод гэжээ.

Энэ үг түүний “Эрүүл энхийн шүлгүүд”-д 10 гаруй удаа давтагджээ.

Нацагдоржийн яруу найргийн, үргэлжилсэн үгийн, жүжгийн зохиолд санскрит, төвд, хятад, латин, англи, франц, орос, герман, араб, перс г.м. олон хэлний үг давхардсан тоогоор 650 гаруй удаа хэрэглэгджээ. Эдгээрээс зарим нэг үгийн гарал төрөл, Нацагдоржийн шинэ цагт хэрэглэсэн туршлага онцлогийг л сонирхвол сонин байж болох. Тухайлбал:

Нэгд: “Зээлийн чимэг” шүлэгтээ **“духи”** гэдэг орос (дух-и) гаралтай, сүрчиг гэсэн утгатай үгийг машид өвөрмөц хэрэглэсэн нь:

Нүдэндээ том гэгчийн дүгрэг шил хийж, хүнтэй уулзвал хөмсгөө зангидна. Нүүртээ бага оо тавьж, хүүхэнтэй уулзвас жаахан духи үнэртүүлнэ... Хичээл эрдэм нь гэвэл хөзөр даалуу, архи, дарс, ял зугаа... гэж. Энд зохиолын баатрын дүрийг тод томруун болгоход **“духи, хөзөр, даалуу, архи... г.м.”** гадаад үгийг хэд хэдийг хэрэглэсэн нь их оновчтой болсон буй.

Хоёрт, Нацагдорж өөрийн зохиолуудад тэр цаг үед төдий л орчуулдаггүй байсан, олон улсын дундын шинжтэй улс ба хотуудын нэр, мөн тэрчлэн Маркс, Ленин, Унгерн тэргүүтэн хүний нэр, **градус**, генерал, доктор, пролетари, гэ-мин (цэрэг), Будда (бурхан багш), лам (эрхэм дээд их багштан), бодисад (бодь сэтгэлтэн), санваар (шашны ёс сахил), микроскоп, гимнастик, лагерь, вокзал, колони, пиво, завод, комбинат, колбаса, гааль, роман, интернациональ, хуанли г.м. элдэв зүйлийн нэрийг монгол хэлэнд хэвшсэн дуудлага ба бичлэгээр нь хэрэглэсэн байдаг. Ийм үгс тун олон байгаа бөгөөд Нацагдоржийн хэрэглэсэн туршлагаас харвал:

...Богд уулын ард

Дөчин **градус** хүйтэн дээ, хүйтэн дээ.

Бяцхан хүүхний өвөрт

Наян **градус** халуун даа, халуун даа... г.м.

Ер, тэгээд бидний монголчууд их Нацагдоржоос хойш бараг 100 жилийн дараа л профессор Чой.Лувсанжав багштаны оноон тохоож, толь бичигт оруулан, олон удаа тайлбарлаж сэнхрүүлж өгсний ачаар л градус-граадус (1925) (gradus) гэдэг латин үгээс нэг салмар болж, сүүлийн 10 жилд **“хэм”, “хэм”** хэцгээж, ярьж бичиж байх шиг санагдана.

Гуравт, Нацагдорж, зохиолууддаа орчин цагийн монгол аман ба бичгийн утга зохиолын хэлэнд орж хэвшээд, монгол үг мэт болж **нутагшсан архи, лан, нярав, феодал, лам, санваар, нирваан, хийд, лус, савдаг, цан, хэнгэрэг, хонх, дамар, гавж, хүж, гүрэм, дором, дуган, лай, зээл, ханз, рашаан, гуанз, гяндан, нанчид, данжаад, ваар, пин, туйпуу, даалуу, чичаан, банз, дүнз, дэнлүү, лаа, дэн, лимбэ, шаахай...** гэх мэт санскрит, араб, перс, хятад, манж, төвд үгсийг монгол бичгээр хэрхэн, яаж бичдэг, дууддаг байсан, тэр л байдлаар нь олонт хэрэглэсэн байдаг. Жишээлбэл:

Ваартай цэцгийн хажуу дор

Бага залуу хоёр зохиолч зугаацан сууж,

Пиво хэмээх **архиар** гэдсээ баясуулан,

Бахтай сонин яриагаар сэтгэлээ хөгжүүлнэ... (“Хоёр зохиолч”),

...Тэрхүү **хийдийн** суварга тэнд гайхамшигтай манжлага цамхаг дор өлгөсөн **хонхны** дуу нь хангинан жингэнэнэ. Бүрээ бишгүүрийн дуун үргэлжлэн донгиноно. **Цам жахар** бүжиглэж буй ажгуу... (“Хөдөө талын үзэсгэлэн” буюу “Амзонка”-гаас) г.м.

Дөрөвт, Нацагдоржийн “Эрүүл энхийн сэдэвт шүлгүүд”-д: **доктор, нян, лейкоцит...г.м** . цөөн хэдэн харь үг үзэгдэнэ. Энд грек гаралтай **“лейкоцит”** гэдэг үгийг хэрэглэж, улмаар “Цусны цагаан дүгрэг” (1935) гэдэг богино таталбартаа **“лейкоцит”**-ийг тайлбарласан нь их сонин болсон.

“Лейкоцит”-ийг **“Цусны цагаан дүгрэг”** гэж монголоор оноогоод, тайлбарыг нь их

Б.Пүрэв-Очир

өвөрмөц, урансайхан хийсэн.

Өгүүлэх нь: Хүний цусны доторх цагаан дүгрэгийг грек хэлээр лейкоцит хэмээх бөгөөд ямар нэгэн өвчин тохиолдохуй дор түүний нян хорхой хүний цусан дор орж үржин, биеийг өвчлүүлэн хорлодог тул, тэрхүү цусны цагаан дүгрэг, түүнийг үзмэгц, жишээлбээс айлын хотон дор чоно орохуй дор гэрийн нохой өмнөөс нь эсэргүүцэн тэмцдэг лүгээ адил, өвчний нян хорхой лугаа тулалдан байлдана.

Аливаа хүний биеийн махбод нь чийрэг болоод, цусны цагаан дүгрэг нь баялаг чадалтай аваас, өвчний хорхой дийлэгдэн, юу ч үйлдэж чадалгүй сөнөнө. Цусны нэгэн хэсэг цагаан дүгрэг ямар нэг өвчний нян хорхойтой учирваас бүхий л цусан дахь бусад нөхдөдөө зарлан дуудах бөгөөд хүчин хавсран бусад нян хорхой лугаа тулалцдаг буй... гэж бичжээ. Тэгэхлээр Нацагдорж, гадаад, харь үгийг зохиол бүтээлдээ санамсаргүй, тохиолдол төдийгөөр ер хэрэглэдэггүй, уг үгийн гарвал, төрөл, утга учрыг судалж, толь бичиг лугаа үзэж нягтлаад, хүн ардаа эгээрүүлэх, гэгээрүүлэх таниулах, сэнхрүүлэх үүдэн зорилгоор хэрэглэдэг их өвөрмөц туршлагатай, бодлоготой байсан нь дээрхээс харагддаг. Өнөөгийн анагаах ухааны клиник лабораторид ч хэрэглэсээр буй “цагаан эс”, “цагаан бөөм” буюу “лейкоцит” гэдэг үгийг эмнэлгийн, олон улсын шинжилгээний практикт лейкоцитийг “WBC” гэж товчлон латин үсгээр тэмдэглэдэг аж. Тэгэхлээр 100 жилийн өмнө уранзохиолд хэрэглэсэн Нацагдоржийн “цусны цагаан дүгрэг” гэдэг грек гаралтай үг өнөөдөр ч хуучраагүй, хэрэглэгдсээр буй нь сонин юм.

ᠵᠢᠵᠦ Тавд, гадаад үгийг уранзохиолд хэрэглэх талд их Нацагдоржийн олж бодсон, хэрэгжүүлсэн нэг сонин туршлага, танин мэдүүлсэн арга бол товчилсон гадаад үгийг шинэ уранзохиолд анх түрүү хэрэглэсэн явдал. Энэ хоёр үг бол “МЮД”, “МАРЗ” хоёр болно. “МЮД”-ийг өмнө тайлбарласан билээ. “МАРЗ” бол сонин товчлол болсон бөгөөд “Таван минут” (1930) таталбартаа:

Таван минутын хугацаа хэдийгээр богино боловч, тархи ухаан таван тив дор хэдэнтээ зугаалан одож, хэдэнтээ эгэж ирэх бөгөөд “МАРЗ”-ын байшингаас дэгдэн гарч, МАРС-ын ертөнц дээр нисэн одвоос харин зуун жилийн зузаан нөхөр наука лугаа учирсан бөгөөд удалгүй МАРС ба МАРЗ хоёрын хооронд замыг нээж, уранзохиолчдыг урин аваачиж, шинэ сониныг үзүүлж хэмээнэ. гэж маш уран сайхан санааг зурсан буй.

“МАРЗ” гэдэг нь “Международная Ассоциация Революционных Зохиолчид” гэсэн товчлол болой.

Зургаад, гадаад үг буюу харь хэлний үгийг монгол үгтэй хоршин хэрэглэсэн тийм арга туршлага 20-30-аад оныхон дотор зөвхөн Нацагдоржид л байсан нь одоо шинжлэхэд сонин байна. Тухайлбал, “заль” гэдэг санскрит гаралтай үгийг “цог”, “суу” гэдэг монгол үгтэй хоршин “цог заль”, “суу заль” гэж; “фантаз” гэдэг грек гаралтай үгийг “дурсхал” гэдэг монгол үгтэй хоршин, “дурсхал фантаз” гэж; “будда” гэдэг санскрит үгийг “бурхан” гэдэг монгол үгтэй хоршин, “бурхан будда” гэж; “мандариваа” гэдэг хятад үгийг “цэцэг” гэдэг монгол үгтэй хоршиж, “мандариваа цэцэг” гэж; “роша” гэдэг орос үгийг “цэцэрлэг” гэдэг монгол үгтэй хоршинхон “роша цэцэрлэг” гэж; “наука” гэдэг орос үгийг “нөхөр” гэдэг монгол үгтэй хоршин зэрэгцүүлж, “нөхөр наука” гэх мэтээр машид сонин, хоёр хэлний хоршоо үгс үүсгэн хэрэглэсэн байна. Жишээнүүд нь:

...Сүлжилдэн давхилдах хөдөөгийн хүмүүсийн цэнгэл нь миний сэтгэлийг даруй бахдуулж, Сан бэйсийн морины сайхан нь миний дурыг хөвсөлзүүлэн хөдөлгөнө. Монгол газар минь уужим юм аа. Маш сайхан морьтой юм аа, морио унаад давхихад манай цог заль сэргэнэ. (“Хөдөө талын үзэсгэлэн”),

Зоригт монголын ач нар, түм түмэн үрс.

Золбоот хөвгүүд охид, цог заль төгс... (“Сэхээтэн”),

...Дараагаар нь бас нэг сүрэг цэцгийн хөг айлчлан ирэх тул, хэдийнээ миний хүсэл мөрөөдөл,

дурсхал фантаз хурим дор бэлтгэсэн ширээний дээрх лүгээ адил зэрэгцэж... (“Нэгэн сэтгэлийг бөмбөрүүлсэн үе”),

Бурхан буддагийн номлолыг үсээ цайтал өдөр бүр уншаад,

.....
Босхалын бялуу шийдмийг өмнөө барьж боссон ямар хорт гар хөл буй?

(“Эсэргүүг сонсвоос”),

Эрүүл явбаас насан хутаг тэр.

Энэ нь гагцхүү өөрийн анхаарал.

Идэр насан хэмээгч нь

Мандариваа цэцгийн адил... (“Залуу нас цэцгийн адил”),

Опел дугуйдаа мордьё доо.

Роша цэцэрлэгтээ очъё доо. (“Шансонет”),

...МАРЗ-ын байшингаас дэгдэн гарч, МАРС-ын ертөнц дээр нисэн одвоос

харин зуун жилийн зузаан нөхөр наука лугаа учирсан бөгөөд... (“Таван минут”) гэх мэт.

Эцэст нь дүгнэн хэлэхэд,

1) Их зохиолч Д.Нацагдорж бол олон хэл, соёлын боловсролтой, гадаад хэлээр зохиол бүтээл олныг уншиж орчуулсан тэргүүний сэхээтэн байсны хувьд, уншигч олон ардаа эгээрүүлэх гэгээрүүлэх, ертөнцийн явдал, шинэ соргог зүйлийг танин мэдүүлэх зорилгоор өөрийн зохиол, бүтээлд гадаад үгийг судалгаатай, зорилготой хэрэглэсэн байна.

2) Хоёр өөр хэл, хоёр өөр соёлын ялгамжааг илэрхийлэх, хүн ардаа төсөөлөл өгөх зорилгоор харь үгийг олонт хэрэглэжээ.

3) Олон улс дундын үгийг нарийн мэдэрч орчуулалгүй хэрэглэсэн өвөрмөц туршлага байна.

4) Зохиолынхоо баатрын дүрийг товойлгох, түүний хэл ярианы онцлогийг гаргах зорилгоор цөөнгүй зохиолдоо гадаад үгийг хэрэглэсэн нь харагдаж байна.

5) Бодит байдал хийгээд зохиолын “хэрэг явдал”, “үйл явдал”-д үнэлэмж өгөх, мэдрэмжээ илэрхийлэх, хошин шог өнгө аяс, зохиолчийн сэтгэлийн хөдөлгөөнөө оруулахад гадаад хэлний үгийг машинд оновчтой хэрэглэсэн туршлага ажиглагдаж байна.

6) Үе үе хээнцэрлэх, чамирхах өнгө аясаар ч зарим гадаад үгийг хэрэглэсэн байгаа тохиолдол ч бий. Үүний нэг баримт бол “Шансонет” шүлэг юм.

v v v

P.S. Их Нацагдоржид “Фольклор”, “Ажлын төлөвлөгөө”, “Тэмдэглэл” г.м. сонирхолтой, бас “Нацагдорж болон түүний...” гэдгийн эргэн тойронд чухаг чухаг мэдээ мэдээллийг зөөж тээж ирсэн “дэвтрүүд” байсан байна.

Энэ дэвтрүүдэд тэр их бичгийн хүн маань хийж бүтээх хэт алсын болон өдөр тутмын ажлаа, санаж сэдэж байсан зүйлээ монгол бичгээр, оросоор, германаар, хааяа энд тэнд англиар тэмдэглэж байсан сонин баримт цөөнгүй байна. Энэ бол манай Нацагдорж, гадаад хэлний, ялангуяа орос, герман хэлний тун чамбай боловсролтой, түүнийгээ амьдрал ахуй, зохиол бүтээлдээ ашиглаж хэрэглэж чаддаг тийм тэргүүний сэхээтэн байсныг харуулж буй юм.

“Ажлын төлөвлөгөө” (Рабочый план~Arbeites plan, 1936) гэх 17 тал тууш шугамтай дэвтэр-энэ дэвтэр бол Дамдины (Хөдөөгийн) Пэрэнлэй гуайгаас Балданы Содном гуайд хүлээлгэн өгсөн дэвтэр юм. Энд сонин хачин, товч тодорхой цөөнгүй тэмдэглэл бий. Тухайлбал,

“Оросын гадаад засгийн төлөөний сайд Коростовецийн зохиосон Монголын түүхээс чухал хэрэглэгдэх үүнийг орчуулах...” (А.Т.8-р тал);

“Эрдэмтэн Бартольдийн зохиосон Монголын байлдан довтолсон үеийн Тюркстан хэмээх дэвтрийг үүсгэн орчуулах...” (А.Т.9-р тал);

“Эрдэмтэн Владимирцовын зохиосон Чингис хэмээх зохиолыг хэвлэн нийтлэх ажлыг үргэлжлүүлэх...” (10-р тал);

Б.Пүрэв-Очир

“Монголын түүхэн дор холбогдох Дөрвөн Ойрадыг нэгтгэсэн Зүүн гарын улсын бичгийг үүсгэн орчуулах...” (А.Т.14-р тал) г.м.-ээр “орчуулах, нийтлүүлэх, хүн ардаа гэгээрүүлэх” ажил олныг сэдэж, өөрөө тэргүүлэн хийж байсан нь тодорхой харагдаж байгаа билээ.

Бас “Нацагдорж: Бүрэн зохиол-3”-д буй “Тэмдэглэл” гэдэг хэсгийг эш үндэс болговол:

Orthographie

Grammatik

Phonetik

Morphographie

Syntax

Linguistik

Philologie

Philosophie

.....

Talent

Phantasie

Methode г.м.-ээр зарим хэл, утга, соёлын нэртомьёог англиар, олон улс дундын үгээр жагсаан тэмдэглэсэн байгаа. Энэ бол зохиолч Нацагдорж хэл бичиг, гүн ухаан, уран зохиол, утга соёлын олон улс дундын нэртомьёо, мэргэжлийн үг хэллэгийг сонирхож, түүнийг сурч, олон шинжлэхүй ухааны салбарыг гадарладаг тийм гадаад хэл, соёлын боловсролтой байсныг харуулдаг.

Бас Нацагдоржийн “Фольклор”, “Ажлын төлөвлөгөө”, “Тэмдэглэл” сэлтэд нэмэн тодосгож, бинтлэн цохолборлосон тийм зүйл цөөнгүй бий. Түүнээс нь хоёрыг сонирхож үзье.

Номзүй

1. Балдан Л. нар, Монгол хэлний сувд эрх нэрт ховор үгийн толь, Уб., 1992.
2. Балжинням Н, Монгол хэлний гадаад үгийн толь, (Монгол-орос-англи), Уб., 2008.
3. Балжинням Н, Монгол хэлний хятад ормол үгийн судалгаа, (Хятад-монгол-орос-англи), Уб., 2011.
4. Дамбажав И, Д.Солонго, Д.Алтан-Од, “Монгольско-Русский словарь по орфографии классического монгольского языка, Прага, 1995.
5. Дамдинсүрэн Ц, А.Лувсандэндэв, “Русско-Монгольский словарь”, Уб., 1982.
6. Кручкин Ю, Большой современный русско-монгольский-монгольско- русский словарь, М., 2006.
7. Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь, (Таван боть), Анхдугаар хэвлэл, Уб., 2008.
8. Нацагдорж Д, “Бүрэн зохиол-1” (Оршил, удиртгал бичиж, тайлбар, номзүй үйлдэн, хэвлэлд бэлтгэсэн Д.Цэдэв), Уб., 2006.
9. Нацагдорж Д, “Бүрэн зохиол-3” (Оршил, удиртгал бичиж, тайлбар, номзүй үйлдэн, хэвлэлд бэлтгэсэн Х.Сампилдэндэв, С.Лочин, Ч.Жачин, А.Очир), Уб., 2006.
10. Д.Нацагдоржийн сонгодог тайламж, Бээжин их сургуулийн монгол судлалын цуврал бичиг, Гуравдугаар боть, 2009 он.
11. Сүхбаатар О, Монгол хэлний харь үгийн толь, Уб., 1999.
12. Цэвэл Я, Монгол хэлний товч тайлбар толь, нэмж дэлгэрүүлсэн хоёрдугаар хэвлэл, (Үг, утга, жишээ, тайлбар, хавсралт тэргүүтнийг нэмж, хянасан Ц.Шагдарсүрэн), Уб., 2013.
13. Цэдэндамба Ц, “Монгол-орос толь”, Уб., 1997.
14. Яцковская К.Н., Дашдоржийн Нацагдорж (Жизнь и творчество) Изд. “Наука”, М., 1974.